

ХУУЛЬЧДЫН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ерөнхий зүйл

Энэхүү журмын зорилго нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих замаар хуульчдын нэр хүндийг өргөх, хамгаалах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлэх явцад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, ажил хэргийн нэр хүндэд халдсан аливаа үйлдлийг өргөдөл, мэдээлэл, гомдлоор эсхүл өөрийн санаачлагаар шалган тогтоох, дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үндэслэл мөн.

Хуульчийн өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхэд Монгол улсын Үндсэн хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Хамрах хүрээ, зарчим

- 2.1. Энэхүү журмаар дараах Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, ажил хэргийн нэр хүндэд халдсан үйлдлийг шалгуулахаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, шалган тогтоох, дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг зохицуулна. Үүнд:
 - 2.1.1. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой
 - 2.1.2. Прокурорын мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой
 - 2.1.3. Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой
 - 2.1.4. Бусад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой
 - 2.1.5. Нотариатын мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой
- 2.2. Энэ журмын 2.1-д зааснаас бусад асуудлаар Хуульчийн эрхлэн хэрэгжүүлэх явцад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, ажил хэргийн нэр хүндэд халдсан аливаа үйлдэлтэй холбоотой өргөдөл, гомдлыг мөн адил шалган шийдвэрлэнэ.
- 2.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.
 - 2.3.1. Хуульчийн эрх, эрх чөлөө, эрх ашгийг хамгаалах
 - 2.3.2. Хараат бус, бие даасан байх,
 - 2.3.3. Ил тод, нээлттэй байх,

Гурав. Хуульчдын эрх, үүрэг

- 3.1. Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч хэн боловч өөрийн эрх хууль ёсны ашиг сонирхол, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хуульчийн нэр хүнд, ажил хэргийн нэр хүнд зөрчигдсэн гэж үзвэл өргөдөл, гомдол гаргах эрхтэй.
- 3.2. Хуульч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа бусад хуульчдын мэргэжлийн үйл ажиллагаа, нэр хүнд, ажил хэргийн нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж, хуульчийн мэргэжлийн ёс зүйг чанд баримтлан ажиллах үүрэгтэй.

Дөрөв. Хорооны үйл ажиллагаа

- 4.1. Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих, энэхүү журмын 2.1-д заасан асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүрэгтэй.
- 4.2. Өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ хороо хуралдаанаар шийдвэрлэж дүгнэлт гаргана. Хорооны хуралдаан нийт гишүүдийн ердийн олонхи ирснээр хүчин төгөлдөр болж шийдвэр нь хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхи дэмжсэн нөхцөлд шийдвэр хүчин төгөлдөр болно.

Тав.Өргөдөл /мэдээлэл/ хүлээн авах, бүртгэх, хуваарилах

- 5.1. Хуульч нь өөрийн мэргэжлийн үйл ажиллагаа, хуульчийн нэр хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан асуудлаар хуульчдын эрхийг хамгаалах хороонд өргөдөл гарна.
- 5.2. Хуульчдын эрхийг хамгаалах хорооны өргөдөл гомдол хүлээн авах мэргэжилтэн өргөдлийг өргөдлийн дэвтэрт бүртгэн авч хорооны даргад ажлын хэсэгт хуваарилуулахаар өргөдлийг авсан өдөрт нь багтаан хорооны даргад хүргүүлнэ.
- 5.3. Цахимаар мэдээлэл авч болох эсэх, тийм бол хавсаргасан баримтыг хэрхэн үнэлэх.
- 5.4. Хуульчдын эрхийг хамгаалах хорооны гишүүн хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих, энэхүү журмын 2.1-д заасан асуудлаар өөрийн санаачлагаар шалгалт явуулахаар хорооны даргад хандаж болно.
- 5.5. Хуульчдын эрхийг хамгаалах хорооны дарга ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хорооны таван гишүүн бүрэлдэхүүнтэй хянаж шалгах ажлын хэсэг байгуулах бөгөөд өргөдөл, гомдлыг ажлын хэсэгт шилжүүлнэ.
- 5.6. Ажлын хэсэгт Прокурорын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл ажлын хэсэгт Улсын ерөнхий прокуророос, Өмгөөлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл Өмгөөлөгчийн хорооноос тус бүр хоёр гишүүнийг оролцоог хангасан байна.
- 5.7. Ажлын хэсгийн гишүүн нь тухайн шийдвэрлэж буй асуудалтай ашиг сонирхлын зөрчилтэй бол сайн дураар татгалзан гарах үүрэгтэй.
- 5.8. Ажлын хэсэг ирүүлсэн асуудалтай холбоотой шалгалтыг 30 хүртлэх хоногийн хугацаанд хийж гүйцэтгэж хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудлаар шийдвэр гаргана.
- 5.9. Шаардлагатай гэж үзвэл ажлын хэсгийн шалгалтын хугацааг Хорооны дарга ажлын 10 хоногийн хугацаагаар сунгаж болно.
- 5.10. Ажлын хэсэг тухайн асуудлаар хэрэг үүсгэх шаардлагагүй гэж үзвэл энэ тухай бичгээр тайлбар гарган өргөдөл гомдол гаргагчид даруй мэдэгдэнэ.
- 5.11. Өргөдөл гомдол гаргагч нь энэ журмын 5.7-д заасан хариуг хүлээн авч хүлээн зөвшөөрөхгүй гэж үзвэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хорооны даргад гомдол гаргана.
- 5.12. Хорооны дарга хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн бол энэ нь тухайн асуудлын хувьд эцсийн шийдвэр байна.
- 5.13. Өргөдөл, гомдолд дурдсан асуудал нь эрх бүхий байгууллагад шалгагдаж буй тохиолдолд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн баталгааг сануулсан мэдэгдлийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.
- 5.14. **Өргөдөл, мэдээлэл, гомдолд дурдсан асуудлыг нууцад хамааруулж хамгаална.**

Зургаа. Шалгах ажиллагаа, шийдвэрлэх хэлбэр

- 6.1. Хорооны гишүүн шаардлагатай тохиолдолд өргөдөл, мэдээлэл гаргагчтай уулзах, санал хүсэлтийг нь сонсох, холбогдох хүн, байгууллагаас тайлбар, баримт бичиг, гаргуулж авахаар албан бичиг хүргүүлэх, холбогдох материалтай

танилцах зэргээр өргөдөл, гомдол, мэдээлэлд дурдсан асуудлыг нэг бүрчлэн шалгана.

- 6.2. Хуульчдын эрхийг хамгаалах хорооноос шалгасан асуудалтай холбогдуулж дараах шийдвэрүүдээс бичгээр гаргана. Үүнд:
 - 6.2.1. Өргөдөлд дурдсан асуудал хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, нэр хүнд, ажил хэргийн хүндэд халдсан болохыг тогтоох,
 - 6.2.2. Халдаагүй тухай тогтоол
 - 6.2.3. Өргөдөл, гомдолд дурдсан асуудал нь хорооны эрхлэх асуудалд хамаарахгүй бол холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх.
- 6.3. Өргөдөл, мэдээлэл, гомдлыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх, хянан шийдвэрлэхгүй дарагдуулахыг хориглоно.

Найм. Стратегийн өмгөөлөл

- 8.1. Хуульчдын эрхийг хамгаалах хороо бусад холбогдох сайн дурын хороотой хамтран хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих, энэхүү журмын 2.1-д заасан асуудлаар стратегийн өмгөөлөл хийж болно.

Ес. Төрийн байгууллагатай харилцах

- 9.1. Ажлын хэсэг хяналт шалгалт, дүгнэлт гаргахтай холбоотой асуудлаар Монголын хуульчдын холбооны холбогдох удирдлагаар дамжуулан төрийн байгууллагатай харилцана.

Арав. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах

- 10.1. Хуульчдын эрхийг хамгаалах хороо гаргасан дүгнэлтээ Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгчөөр баталгаажуулж олон нийтэд мэдээлнэ.
- 10.2. Мэдээлэх ажлыг Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Тамгын газрын дарга зохион байгуулна.
- 10.3. Хороо нь хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд тогтмол мэдээлж байна.

Арван нэг. Санхүүжилт

- 11.1. Хорооны үйл ажиллагааны зардлыг хороо өөрөө хариуцна.
- 11.2. Хянан шалгах ажлын хэсгийн гишүүдэд ажилласан ажлын хэсэг тус бүрт урамшуулал олгоно. Урамшуулал олгох асуудлыг хороо санал гаргаж тамгын газраар батлуулна.

Арван хоёр. Бусад

- 12.1. Энэхүү журмыг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.